



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/109

Мөрөн сум

Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн
мөнгийг буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны жилийн эцэст аймгийн төрийн санд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 296,089,103.90 (Хоёр зуун ерэн зургаан сая наян есөн мянга нэг зуун гурван төгрөг 90 мөнгө) төгрөг, Санхүү хяналт дотоод аудитын албаны нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 600,300 (Зургаан зуун мянга гурван зуу) төгрөгийг тухайн байгууллагуудад буцаан олгосугай.

2.Асрамжийн газрын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 23,600 (Хорин гурван мянга зургаан зуу) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 2.139,072 (Хоёр сая нэг зуун гучин есөн мянга далан хоёр) төгрөг, Орон нутгийн өмчийн газрын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 1,600 (Нэг мянга зургаан зуу) төгрөгийг орон нутгийн орлогод тооцсугай.

3.Нэгдүгээр заалтын дагуу 296,689,403.90 (Хоёр зуун ерэн зургаан сая зургаан зуун наян есөн мянга дөрвөн зуун гурван төгрөг 90 мөнгө) төгрөгийг төсвийн байгууллагуудад буцаан олгож, хоёрдугаар заалтын дагуу 2,164,272 (Хоёр сая нэг зуун жаран дөрвөн мянга хоёр зуун далан хоёр) төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), аймгийн төсвийн ерөнхий нягтлан (Л.Батжаргал) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



671.010332